

ЭРДЭНЭЦАГААН СУМ

2022 ОНЫ 9 ДУГААР САРЫН МЭДЭЭ

Хууль, эрх зүй, удирдлага зохион байгуулалтын хүрээнд: ,

Аймгийн засаг даргын 06 тоот албан даалгавар, Сумын засаг даргын 03 тоот албан даалгаврын дагуу Төсөвт байгууллагуудад өвөлжилт, хаваржилтийн бэлэн байдлыг шалгах ажлын хэсэг удирдамжийн дагуу ажиллалаа. Аймгийн ИТХ-н дарга Д.Хосбаяраар ахлуулсан ажлын хэсэг 22-ны өдөр ажиллалаа. Худалдаа үйлчилгээний газруудад үүрэг болгож өгсөн СЗД-ын 01 тоот албан даалгавар, хууль тогтоомжуудийн биелэлтийг хангаж болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх зөвлөмж зэргийг биелэлтийг 10 дугаар сарын эхний 7 хоногт шалгах удирдамж гаргаж ажилласан. 09-р сарын 26-нд Төрийн албан хаагчдын “Нээлттэй хаалганы өдөрлөг” болон “Алтан намар 2022” үзэсгэлэн худалдааг зохион байгуулсан.

Архив, албан хэрэг хөтлөлтийн ажлын хүрээнд:

2021 оны 09 дүгээр сард Сумын Засаг даргын захирамж -10 , Албан тоот- 6, Тамгын газрын даргын тушаал-7-ыг тус тус стандартын дагуу гаргаж ажиллалаа. Мөн ирсэн бичиг-11 хүлээн авч бүртгэн хариутай 5 бичгийн хариунд хяналт тавьж, 3 өргөдөл гомдол ирснийг өргөдөл гомдлын бүртгэлд бүртгэн холбогдох албан тушаалтанд танилцуулж хариуг иргэнд мэдэгдэж шийдвэрлэж ажилласан.

Хөдөө аж ахуйн чиглэлээр : Хадлан тэжээл бэлтгэлт 39 хадлангийн салаа хэсэг 9600 га талбайд хадлан тэжээл бэлтгэж байна. сумын аюулгүйн нөөцөд 20 тн өвс, 5 тэжээл нөөцөлсөн. Үлдэгдэл 80 тн өвсийг 10-р сарын 1 ны дотор бүрэн нөөцөллөж дуусгана.

Аймгийн ХААГ-ын газрын дарга хадлан тэжээл бэлтгэж байгаа салаа хэсгүүдтэй танилцаж, газрын зөвшөөрөл бусад бичиг баримттай танилцаж явсан. Мөн ангилалт, ээмэгжүүлэлтийн ажилтай танилцаж заавар зөвөлгөө өгч, сайн чанарын махны чиглэлийн адуу, үхэр, хонин сүргийн сууриудаар орж үүлдэр угсааг баталгаажуулах талаар зөвлөсөн.

Дутагдах хээлтүүлэгчийг нөхөн тавих ажлыг эрчимжүүлэх, отор нүүдлийн судалгааг мал эмнэлгийн байгууллагаас авах, мал эмнэлгийн бичгийг үндэслэн отор нүүдэл оруулах шаардлага тавьсан. Тариалан эрхлэгчдийн бүртгэл мэдээллийн шинэ цахим программтай болсон. Сумын хэмжээнд 12 тариалан эрхлэгч иргэн, 1 аж ахуйн нэгжийн бүртгэл хийгдэнэ. Өнөөдрийн байдлаар 135235 толгой мал төл хүлээн авсан байна. мал төллөлт 73,8 хувьтай байна.

Төсөв санхүүгийн хүрээнд: Сумын төсвийн орлогыг 1,106.8 сая төгрөгөөр төсөвлөсөнөөр гүйцэтгэл 553.4 сая төгрөгийг төвлөрүүлэн 50.2 хувийн биелэлттэй байна./Үүнээс малын тоо толгойд ногдуулах албан татвар 284.0 сая төгрөг төвлөрүүлэхээс 89.9 сая төгрөг төвлөрсөн/ Орон нутгийн 2 байгууллага ОНХС-ийн санхүүжилтанд зардлын гүйцэтгэл 720.4 сая төгрөг зарцуулаад байна. ОНХС-ын эх үүсвэрээр 1,828.2 сая төгрөгөөр 57 хөтөлбөр арга хэмжээг баталж 764.1 сая төгрөгийн санхүүжилт ирснээс гүйцэтгэлээр 38 хөтөлбөр арга хэмжээнд 920.4 сая төгрөгийг зарцуулаад байна. Сум хөгжүүлэх сангийн журам нь шинэчлэгдэж Хоршоо хөгжүүлэх сан болсон одоогоор хоршоодод зээл олгогдоогүй сангийн үлдэгдэл 101.3 сая төгрөг байна.

Өр авлага одоогийн байдлаар: Орон нутгийн төсвийн хүрээнд өрийн байдал одоогоор үүсээгүй байна. Тусгай зориулалты шилжүүлэгийн байгууллагуудад өр үүссээд байна. Үүнд: Хоол хүнс- 1-р цэцэрлэг- 3.1 сая төгрөг
Түлш халаалт - - ЭМТөв- 6.6 сая төгрөг

- ЕБСургууль -8.0 сая төгрөг
- СТөв - 9.6 сая төгрөг

Гэрэл цахилгаан - 2-р цэцэрлэг 1.8 сая төгрөг буюу нийт 25.2 сая төгрөгийг өр үүсээд байна. Үүний хүрээнд аймгийн төрийн сан болон холбогдох газруудад албан тоот хүргүлэн ажилласан. ТЗШ-ийн байгууллагын санхүүжилт аймгаас учраас аймгийн орлого тасарсан учраас хойшлогдоод байгаа гэсэн хариуг өгсөн.

Гамшгийн хүрээнд – Арьс товруутах өвчний хүрээнд хуулийн хүрээнд ОНХС-аас Малын эрүүл мэндийг хамгаалах ажлын хүрээнд 15.0 сая төгрөгийг төлөвлөж гүйцэтгэл 100%-ийн зарцуулалттай байна. Гоц халдварт өвчний голомтыг арилгах 20.0 сая төгрөг төсөвлөснөөс 12.0 сая төгрөгийн гүйцэтгэлтэй байна. Үүнд Арьс товруутах өвчний шатахуун, хээрийн түймрийн шатахуунаас зардалд зарцуулагдсан байна.

Гэр бүл хүүхэд хамгааллын хүрээнд:

Гэр бүлийн хүчирхийллийн 1 холбогдогчидтой уулзаж гэр бүлийн хүчирхийллийн нөхцөл байдлын үнэлгээ, гэр бүлийн байдлын нөхцөл байдлын үнэлгээ зэргийг хийж, хүүхдийн эрсдлийн үнэлгээ хийж ГБХЗХГ-т мэдэгдсэн. Гэр бүлийн салалтаас шалтгаалсан хүүхэдтэйгээ уулзах боломжгүй байгаа гэсэн гомдлыг холбогдох байгууллагуудтай хамтарч шалган гомдол гаргагчид эргэн мэдээлж хууль зүйн зөвөлгөө өгсөн. Хүүхэд харах үйлчилгээ эрхлэх хүсэлт гаргасан 1 иргэн эрх зүйн зөвөлгөө өгч, хүүхэд харах байранд үнэлгээ хийж удирдлагад танилцуулав. Хүүхэд харах үйлчилгээний байранд 2 удаа хуулийн дагуу шалгалт явуулж зөвөлгөө өгч, холбогдох судалгаа материалыг ГБХЗХГ-т хүргүүлэв.

Амьтны аймаг,ТББ гамшгийн чиглэлээр.

Зотол хайрханд нутагшуулсан Монгол тарваганд 2022 оны 09-р сарын 17-ны өдөр хяналт шалгалтын ажлыг хийлээ. Оройн гараа эргэлтээр тус газар 6 мөндий, 5 том тарвага гарсан байхыг нүдээр харж тоолсон байна. 09-р сарын 18-нд Хуран ууланд байрлах тарваганд хяналт шалгалтыг хийж 9-н мөндий 13-н том тарвага тоологдсон байна.Мөн 19-нд Хуран уулын урд энгэр болон Халзан хаданд 28-н мөндий, 23-н том тарвага тоолсон байна. 09-р сарын 20-нд Чандмана овоонд байрлах монгол тарваганд хяналт шалгалт хийж 2 том тарвага тоологдсон байна. Мөн 7-р багийн нутаг болох Мандал овоонд 2 том тарвага 2 мөндий шинээр тоологдож бүртгэгдсэн байна .9-н сарын эргүүл хяналтаар нийт-45 мөндий, 45-н том тарвага тоологдсон байна Сумын засаг даргын А/167 тоот захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг “Тэр бум мод үндэсний хөдөлгөөн”-өөр тарьсан модонд хяналт шалгалт мониторингын ажлыг зохион байгуулж тайлан мэдээг холбогдох газруудад хүргүүлж ажилласан байна.

Мэдээлэл технологийн ажлын хүрээнд:

- Erdenetsagaan.su.gov.mn вэб сайт, “Засаг даргын тамгын газар” пэйж хуудасаар дамжуулж ОНХС хөрөнгө оруултаар хийгдэж байгаа бүтээн байгуулалтын ажил, цаг үеийн мэдээ мэдээллийг нийтэлж олон нийтэд мэдээллэж ажилласан.
- Шинэлэг ажил: 7 хоног бүр нэг албан хаагчаар шаардлагатай ажлын тухай богино хэмжээний видео хийж “Засаг даргын тамгын газар” пэйж хуудсаар дамжуулан иргэдэд мэдээлэл хүргэж байна.

Малын халдварт үхрийн товруутах өвчин гарч, МЭТ болон багийн малын эмч нар ажиллаж байна. Одоогийн байдлаар 2 голомтын, 6 өрхийн, **нийт 65** үхрийг устгаад байна. Үүнээс 6-р багт **58 үхэр**, 1-р багт **7** үхрийг устгаад байна.